



ГОВЬСҮМБЭР АЙМАГ
БАЯНТАЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2025 оны 06 сарын 19 өдөр

Дугаар А/13

Баянтал сум

Албан тушаалын нэр, индекс батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын "Журам батлах тухай" 2024 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 214 дүгээр тогтоолоор батлагдсан "Албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журмын 2.2.4, Зохион байгуулалт захирамжлалын баримт бичгийн MNS 5140-2011 стандартыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Засаг даргын тамгын газрын албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд мөрдөх албан тушаалын нэр индексийг хавсралтаар баталсугай.

2.Албан тушаалын нэр индексийг албан бичгийн өмнө хослуулан хэрэглэж, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг хууль эрх зүйн мэргэжилтэн (Ц.Булган)-д үүрэг болгосугай.

3.Энэ тушаалыг 2025 оны 07 дугаар сарын 09-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй .

ДАРГА  Ш.ШИНЭБАЯР

Засаг даргын Тамгын газрын даргын
2025 оны 06 дугаар сарын 12 ны
өдрийн 13 дугаар тушаалын
хавсралт



№	Албан тушаалын нэр	Индекс
1	Засаг дарга	01
2	Засаг даргын орлогч	02
3	Засаг даргын Тамгын газрын дарга	03
4	Лүн багийн засаг дарга	04
5	Их -Уул багийн засаг дарга	05
6	Санхүү албаны дарга	06



ГОВЬСҮМБЭР АЙМАГ
БАЯНТАЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2025 оны 06 сарын 19 өдөр

Дугаар А/14

Баянтал сум

Эд хөрөнгийн тооллого явуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, тууний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.4, 67.5, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46.1, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2.1, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 72 дугаар зүйлийн 72.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Сумын Засаг даргын Тамгын газрын эд хөрөнгийн 2025 оны хагас жилийн тооллогыг 2025 оны 06 дугаар сарын 19-ний өдрөөс 2025 оны 06 дугаар сарын 26-ны өдрийг хүртэл явуулсугай.

2. Эд хөрөнгийн тооллого явуулах комиссыг доорх бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Комиссын дарга :

Ц.Болдбаатар

(Засаг даргын Тамгын газрын жижүүр)

Гишүүд:

О.Бадамдорж

(Засаг даргын Тамгын газрын жолооч)

Н.Мөнгөнцэцэг

Нарийн бичгийн дарга:

(Архив, бичиг хэргийн эрхлэгч)

3.Эд хөрөнгийн тооллогыг үнэн зөв, чанартай, нэг бүрчлэн тоолж жагсаалтаар бүртгэн, дунг 2025 оны 06 дугаар сарын 30-ны дотор танилцуулахыг комиссын дарга (Ц.Болдбаатар)-т даалгасугай.

ДАРГА



Ш.ШИНЭБАЯР

